



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/05

Чойр

Газар эзэмших эрхийг дуусгавар
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4, 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Эрүүл мэндийн газар нь Сүмбэр сумын 1 дүгээр баг Нэгдсэн эмнэлгийн баруун урд талд байрлах албан байрны зориулалттай 0.15 га газрыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй тул 4201000296 нэгж талбарын дугаартай, 0178091 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгон газар эзэмших эрхийг дуусгавар болгосугай.

2.Газар эзэмших эрх дуусгавар болгосныг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга (Ц.Мөнх-Од)-д мэдэгдэж, газар эзэмших эрхийн гэрчилгээ болоч гэрээг хүлээж авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Отгончимэг)-д үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2012 оны А/308 дугаартай захирамжийг хүчингүй болсонд тооцугай.

ЗАСАГ ДАРГА

Г.БАТЗАМ